

БНХАУ-ЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ч.Батцэцэг*

Газарзүй:

БНХАУ нь 9,6 сая ам.дөр.км нутагтай. Хуурай газрын хилийн урт 22,8 мян. км. Хойгуураа Монгол Улстай 4,677 км, зүүн зүгтээ БНАСАУ-тай 1,416 км, зүүн хойгуураа ОХУ-тай 3,605 км, баруун хойгуураа Казахстантай 1,533 км, Кыргызстантай 858 км, Тажикстантай 414 км, баруугаар болон баруун урдуураа Афганистантай 76 км, Пакистантай 523 км, Энэтхэгтэй 3,380 км, Балбатай 1,236 км, Бугантай 470 км газраар тус тус хиллэж, урдуураа Бирмтэй 2,185 км, Лаостай 423 км, Вьетнамтай 1,281 км газраар зэргэлдээ оршдог. Зүүн талаараа болон зүүн урдуураа БНСУ, Япон, Филиппин, Бруней, Малайз, Индонез гэх мэт улсуудтай далайгаар хиллэдэг.

Хятадын эх газрын бүсийн эргийн шугам 18 мян.км урт үргэлжилнэ. Хятад нь дорно болон өмнө зүгтээ Бохай, Шар тэнгис, Дорнод Хятадын болон Өмнөд Хятадын тэнгисээр хүрээлэгддэг. Нутаг дэвсгэрийн усны нийт талбай 4,73 сая ам.дөр.км.

Хятадыг хүрээлдэг тэнгист 5400 арал таран байрладаг. Тэдгээрийн томоохон нь –Тайвань, 36 мян.ам.дөр.км талбайтай, дараа нь Хайнань арал орно. Түүний талбай –34 мян.ам.дөр.км.

Газарзүйн онцлог:

Хятад нь уулархаг, нийт нутаг дэвсгэрийн 2/3-ыг уул, толгод, дов гүвээ, өндөрлөг газар эзэлдэг. Нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 33%-ийг уулс, ойролцоогоор 26%-ийг өндөрлөг газар, ойролцоогоор 19%-ийг хотгор, ойролцоогоор 12%-ийг тал хөндий,

ойролцоогоор 10%-ийг гүвээ толгод тус тус бүрдүүлнэ.

Хятадын нутаг дэвсгэр өрнөөс дорно руу буун ирж буй мэт 4 давхар шатыг санагдуулам. Энэхүү “шатны” хамгийн өндөр шат нь Цинхай -Түвдийн өндөрлөг газар бүрдүүлэх ба дундаж өндөр нь далайн төвшнөөс дээш 4000 м гаруй бөгөөд заримдаа “дэлхийн дээвэр” хэмээгддэг. Хоёрдахь өндөр шат нь Өвөр Монголын уулс, Алтан химэрлэг газар, Юньнань-Гуйжоугийн уулс, Таримын хотгор газар, Зүүнгар болон Сычуаний хонхор газрууд бүрдүүлнэ. Энд дундаж өндөр нь далайн төвшнөөс дээш 1000-2000 м байна. Их Хянганы нурууны бэлээс Тайханшань уул, Ушань уул, Сюефэншань уул зүүн зүгтээ дорнод эрэг орчимд хүрч гуравдахь шат болон үргэлжилж, өндөр нь далайн төвшнөөс дээш 500-1000 м бууна. Дөрөвдэх шат нь эх газрын зах хязгаар далайн төвшнөөс доошоо гүнд байрлана.

Хятадад тариалангийн талбай 125,93 сая га, ой модны талбай 230,72 сая га, бэлчээр газар 263,52 сая га байна. Хятадын ой – 158,94 сая га.талбайтай.

Байгалийн нөөц, ашигт малтмал: нүүрс, төмөр, нефть, байгалийн хий, мөнгөн ус, цагаан тугалга, вольфрам, сурьма, марганц, молибден, ванадиум, соронзон (магнет), хөнгөн цагаан, хар тугалга, цайр, уран, усны эрчим хүч г.м

Цаг уур:

Хятад нь: экваторын, халуун, дулаан, дулаавтар, сэрүүн, сэрүүвтэр уур амьсгал гэсэн цаг уурын 6 бүстэй. Хур тундасны хэмжээ зүүн-өмнөөс баруун хойшоо

* Ч.Батцэцэг. ШУА-ийн ОУСХ-ийн ахлах ажилтан, (Ph.D) доктор

аажмаар багасна, нутгийн бүх газар хур тундасны дундаж тоо маш их ялгаатай, зүүн өмнө зүгтээ 1500 мм, баруун хойд зүгт зөвхөн 200 мм байна. Зүүн хойд Хятадын ихэнхи нутгаар өвөл хүйтэн, 1-р сард дунджаар 30 хэм хүйтэн байхад, Хайнань мужид энэ үед 20 хэмээс дээш дулаан байна.

Хүн ам, үндэстэн:

Хятад улс хүн амын тоогоороо дэлхийд эхний байр эзэлдэг бөгөөд барагцаалбал 1,286,975,468 (2003 оны 7-р сарын байдлаар) хүн амтай. (Сянган, Аомынь, Тайваний хүн амыг багтаасан) өөрөөр хэлбэл, дэлхийн нийт хүн амын 1/5-ээс илүү хувийг эзэлдэг. Мөн дэлхийн хамгийн нягт шигүү суудаг хүн амтай орны нэг. (Хүн амын дундаж нягтрал -1 ам.дөр.км талбайд 135 хүн ногдоно.)

Хятадын хуурай эх газрын хүн амын тоог 1284,53 сая хүн бүрдүүлж байгаагаас хот, суурин газрын хүн амын тоо -502,12 сая буюу нутгийн нийт хүн амын тооны 39,1%, хөдөөгийн хүн амын тоо 782,41 сая буюу 60,9% байна. Хүн амын 661,15 сая нь эрэгтэй, 623,38 сая нь эмэгтэй. Хүн амын хувийн жинг авч үзвэл: 14-өөс доош насных 23,1%, 15-64 хүртэлх насны хүн 69,5%, ахмадуудын хувийн жин 65 түүнээс дээш насны хүн 7,4% буюу тэдгээрийн тоо 93,77 саяд хүрчээ.

Хүн амын цэвэр өсөлт 2003 онд -0,6 %-тай байна. Төрөлт 12.96 (1000 хүн тутамд), нас баралт 6,74 (1000 хүн тутамд) (2003 оны байдлаар), хүн амын шилжилт 0,23 хүн (1000 хүн тутамд) байна.

Хятад улс олон үндэстний орон - нийт 56 үндэстэн оршин суудаг ба Хятадын нийт хүн амын ойролцоогоор 92%-ийг хань үндэстэн, бусад 55 үндэстэн 8%-ийг бүрдүүлдэг. 18 үндэстний цөөнхийн нийт хүн ам 1 саяас илүү байна. Хамгийн их тоотой угсаатан нь жуан -15,5 сая хүнээс дээш, хамгийн бага тоотой нь лоба -(2300 гаруй хүн) болно.

Шашин шүтлэг: Даогийн үзэл, бурхны шашин (бүдда), лалын шашин (ислам) 1%-2%, загалмайтны (христийн) шашин 3%-4%.

Бичиг үсэгтэй: уншиж бичиж чаддаг 15-аас дээш насны хүн ам нийт 86%, үүнээс эр нь 92,2%, эм нь 78,8% (2003 оны байдлаар) байна.

Засаг захиргааны хуваарь:

БНХАУ нь Үндсэн хуулийнхаа дагуу засаг захиргааны дараах хуваарилалтыг хийсэн байна. Үүнд :

1. Муж болон өөртөө засах орнууд, төвийн харъяаллын хотууд;
2. Мужууд болон өөртөө засах орнууд нь өөртөө засах тойрог, хошуу (сянь), өөртөө засах хошуу, хотуудад;
3. Тойргууд нь өөртөө засах хошуу (сянь) болон суурин болж хуваагдсан хотууд, үндэстний сум, гацаа, тосгон сууринд тус тус хуваагддаг.

Одоогийн байдлаар тус орон төвийн харъяаллын 4 хот, 23 муж, өөртөө засах орон 5 болон засаг захиргааны онцгой 2 дүүрэгтэй (район) байна.

**БНХАУ-ын засаг захиргааны хуваарилалт
(2001 оны 12-р сарын 31-ний байдлаар)**

	Тойргийн тоо	Хошуу (сянь)-ны тоо	Хотын дүүргүүдийн тоо
Нийт нутаг	332	2053	808
Бээжин хот		2	16
Тяньжин хот		3	15
Хэбэй муж	11	138	35

Шаньси муж	11	97	22
ӨМӨЗО	12	82	19
Ляонин муж	14	44	56
Жилинь	9	41	19
Хэйлунзян муж	13	66	64
Шанхай хот		1	18
Зянсу муж	13	58	50
Жэзян муж	11	59	29
Аньхой муж	17	61	44
Фузянь муж	9	60	25
Зянси муж	11	80	19
Шаньдун муж	17	91	48
Хэнань муж	17	110	48
Хубэй муж	13	64	38
Хунань муж	14	88	34
Гуандун муж	21	76	48
Гуанси-Жуаны ӨЗО	14	81	28
Хайнань муж	2	17	3
Чунцин хот		25	15
Сычуань муж	21	139	41
Гуйжоу	9	78	9
Юньнань муж	16	119	9
Түвдийн ӨЗО	7	72	1
Шэньси муж	10	86	21
Ганьсу муж	14	75	11
Цинхай муж	8	39	4
Нинся-Хуэйн ӨЗО	4	16	8
Синьзян-Уйгурын ӨЗО	14	85	11
Сянган			
Аомэнь			
Тайвань			

Улс төр:
 Улсын нэр: Бүгд Найрамдах Хятад Ард Улс
 Товчилсон нэр: Хятад
 Орон нутгийн товчилсон хэлбэр: Жунго Дэлгэрэнгүй нэр нь: Жунхуа рэнминь гунхэго
 Англиар товчилбол: PRC
 Нийслэл: Бээжин хот.
 Үндэсний баяр: 10-р сарын 1 БНХАУ байгуулагдсаны ойн баярын өдөр (1949.10.1)
 Үндсэн хууль: 1982 оны 12-р сарын 4-нд баталсан нь өнөөг хүртэл хүчинтэй байна.

БНХАУ-ын Үндсэн хуулийн дагуу төвийн хэмжээний 6 засаглалын бүтэцтэй. Үүнд: Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ), түүний Байнгын Хороо, БНХАУ-ын дарга, Төрийн Зөвлөл, Цэргийн Төв Зөвлөл, Ардын Дээд Шүүх болон Ардын Дээд Прокурорын Газар багтана. БНХАУ-ын дарга, Төрийн Зөвлөл, Цэргийн Төв Зөвлөл, Ардын Дээд Шүүх болон Ардын Дээд Прокурорын Газар нь Бүх Хятадын Их Хурлын ардын төлөөлөгчдийг бүрдүүлж, түүний Байнгын Хороонд тайлагнадаг.

**Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал
(БХАТИХ)-ын 10 чуулган**

Чуулган	Чуулсан жил	Депутатын тоо	БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга
БХАТИХ-ын 1-р чуулган	1954 оны 9-р сар	1226	Лю Шаоци
2-р чуулган	1959 оны 4-р сар	1226	Жү Дэ
3-р чуулган	1964 оны 12-р сар	3040	Жү Дэ
4-р чуулган	1975 оны 1-р сар	2885	Жү Дэ
5-р чуулган	1978 оны 3-р сар	3479	У Зяньин
6-р чуулган	1983 оны 6-р сар	2978	Пэн Жэнь
7-р чуулган	1988 оны 3-р сар	2970	Вань Ли
8-р чуулган	1993 оны 3-р сар	2898	Цяо Ши
9-р чуулган	1998 оны 3-р сар	2978	Ли Пэн
10-р чуулган	2003 оны 3-р сар	2985	У Банго

БНХАУ-ын дарга:
 БНХАУ-ын дарга бол төрийн тэргүүн. БНХАУ-ын дарга, түүний орлогчийг БХАТИХ-аар сонгох ба даргын албан тушаал, бүрэн эрхийг БХАТИХ-аар чөлөөлнө. Даргын бүрэн эрхт хугацаа-5 жил байна.

БНХАУ-ын өмнөх жилүүдийн дарга нар: Мао Зэдун, Лю Шаоци, Ли Сяньнянь, Ян Шанкунь, Зян Зэминь.

БХАТИХ-ын 10-р чуулганы анхдугаар хурлаар Ху Жиньтао БНХАУ-ын даргаар, орлогч даргаар Зэн Цинхун нар сонгогдсон байна.

Хууль тогтоох дээд байгууллага: Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (2,985 суудалтай, гишүүд нь орон нутгийн, бүс нутгийн болон мужийн ардын төлөөлөгчдийн хурлаас 5 жилийн хугацаатай сонгогдоно.)

БНХАУ-ын Төрийн Зөвлөл:

БНХАУ-ын Төрийн Зөвлөл нь Ардын Төв Засгийн газар, улсын гүйцэтгэх засаглалын дээд байгууллага болно. Төрийн Зөвлөл нь БХАТИХ, түүний Байнгын Хорооноос баталж, боловсруулсан шийдвэр, хууль тогтоолийг амьдралд хэрэгжүүлэх ба тэдэнд тайлагнана. Төрийн Зөвлөлийн бүрэлдэхүүнд ерөнхий сайд, Төрийн Зөвлөлийн гишүүд, яамдын болон улсын хороодын сайд, ерөнхий шалган байцаагч, хариуцлагатай нарийн бичгийн дарга нар багтана. БНХАУ-ын дарга ерөнхий сайдад нэр дэвшүүлж, БХАТИХ-аар батална, БНХАУ-ын дарга Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдыг томилох ба огцруулна. Бүрэн эрхт хугацаа 5 жил.

2003 оны 3-р сарын 16-нд БХАТИХ-ын анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын дарга Ху Жиньтаогийн зарлигаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдаар Вэнь Зябог томилжээ.

Шүүх засаглал:

Ардын Дээд Шүүх (БХАТИХ-аас томилж шийдвэр гаргана), Орон нутгийн Ардын Шүүх (орон нутгийн шүүх дээд доод төвшинд зөвшилцөнө), Ардын тусгай шүүх (анхан шатны цэргийн болон далайн цэргийн шүүх, тээвэр, төмөр замын шүүх) багтана.

Улс төрийн намууд: Хятадын Коммунист Нам буюу ХКН (ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жиньтао), үүнээс гадна ардчилсан намын бүртгэлтэй гэх 8 нам байдаг.

Эдийн засаг:

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ): худалдан авах чадвар-5.989 триллион ам.долл (2002 оны байдлаар).

ДНБ-ий бодит өсөлт: 8% (2002 оны байдлаар)

ДНБ нэг хүнд ногдох: худалдан авах чадвар-4,700 ам.долл (2002 оны байдлаар)

ДНБ-ий секторын бүрэлдэхүүн: хөдөө аж ахуй-15.29, аж үйлдвэр, барилга

байгууламж-51.2%, үйлчилгээ-33.6% (2001 оны байдлаар)

Хүн амын ядуурлын доод хэмжээ: 10% (2001 оны байдлаар)

Аж ахуйн орлого буюу хэрэгцээний хувь: доод хэмжээ 10%: 2,4%, дээд хэмжээ-10%:30.4% (1998 оны байдлаар)

Гэр бүлийн орлогын хуваарилалт: 40 (2001 оны байдлаар)

Инфляцийн хэмжээ (хэрэглээний өртөг): - 0,8%

Хөдөлмөрийн хүч: 744 сая

Хөдөлмөрийн хүчний ажил эрхлэлт: хөдөө аж ахуй 50%, аж үйлдвэр 22%, үйлчилгээ 28% (2001 оны байдлаар)

Ажилгүйдлийн хэмжээ: хотын ажилгүйдэл 10%, хөдөө нутаг дахь ажилгүйдлийн бодит байдал түүнээс доод хэмжээнд байна. (2002 оны байдлаар)

Төсөв: орлого-224.8 тэрбум, зарлага-267.1 тэрбум.

Аж үйлдвэр: ган төмөр, нүүрс, барилгын тоног төхөөрөмж, зэвсгийн, нэхмэл болон бэлэн хувцас, нефть, цемент, химийн бордоо, гутал, тоглоом, хүнс боловсруулах, автомашин, цахилгаан хэрэглээний, телефон утасны сүлжээний үйлдвэр г.м.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийн хэмжээ: 12.6% (2002 оны байдлаар)

Эрчим хүч: 1.42 триллион квт/цаг (2001 оны байдлаар)

Эрчим хүчний эх сурвалж: түлш-80.2%, ус-18.5%, бусад-0.1%, цөм-1.2%.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ зарлага: 1.312 триллион квт/цаг (2001 он)

Цахилгаан эрчим хүчний экспорт: 10.3 тэрбум квт/цаг (2001 оных)

Цахилгаан эрчим хүчний импорт: 1.55 тэрбум квт/цаг (2001 он)

Нефтийн бүтээгдэхүүн: 3.3 сая баррель/өдөр (2001 он)

Нефтийн хэрэглээ зарлага: 4.975 сая баррель/өдөр (2001 он)

Нефтийн нөөц: 26.75 тэрбум баррель

Байгалийн хийн бүтээгдэхүүн: 30.3 тэрбум шоо/м (2001 он)

Байгалийн хийн хэрэглээ, зарлага: 30.3 тэрбум шоо/м (2001 он)

Байгалийн хийн нөөц: 1.29 триллион шоо/м

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн: будаа, амуу тариа, улаан буудай, төмс, самар, цай, хар, шар будаа, арвай, хөвөн, ургамлын тос, гахай, загас.

Экспорт: 325.6 тэрбум (2002 он)

Экспортын бүтээгдэхүүн: машин, тоног төхөөрөмж, нэхмэл болон ноосон даавуу, гутал, тоглоом, биеийн тамирын эд бараа, эрдэс бордоо.

Экспортын түншүүд: АНУ 21.5%, Хонг Конг 18%, Япон 14.9%, Өмнөд Солонгос 4.8% (2002 оны байдлаар)

Импорт: 295.3 тэрбум

Импортын бүтээгдэхүүн: машин, тоног төхөөрөмж, эрдэс бордоо, хуванцар, төмөр, ган, химийн бүтээгдэхүүн

Импортын түншүүд: Япон 18.1%, Тайвань 10.5%, Өмнөд Солонгос 9.7%, АНУ 9.2%, Герман 5.6% (2002 он)

Мөнгөн тэмдэгт: юань

Цахилгаан холбоо:

Телефон утасны хэрэглээний гол шугам: 135 сая

Үүрэн телефон утас: 65 сая

Телефон-утасны систем: ерөнхий сүлжээ: орон нутгийн болон олон улсын үйлчилгээний хувийн хэрэгцээ өсч, дотоодын үйлчилгээг үндсэн хотууд, аж үйлдвэрийн төвүүд болон бусад олон хотод тэнцүү бус хуваарилсан байдаг.

Орон нутгийн дотоодын сүлжээ: олон улсын муж хооронд шилэн кабелийн шугам, үйлчилгээний телефон-утасны системтэй, орон нутгийн 55 газар сателлайт (satellite) системтэй, олон улсад: сателлайт (satellite) станц – 5 интелсат (intelsat) (Номхон далай 4, Энэтхэгийн далай 1), интерспутник (intersputnik) (Энэтхэгийн далайн бүс нутаг), инмарсат (Inmarsat) (Номхон далай

болон Энэтхэгийн далайн бүс нутаг); Япон, Өмнөд Солонгос, Хонг Конг, Орос болон Герман зэрэг улстай олон улсын үйлчилгээний шилэн кабелийн шугамтай.

Радио станцын тархалт: АМ 369, FM 259, богино долгион 45

Радио: 417 сая (1997 оны байдлаар)

Телевизийн станцын тархалт: 3,240 (үүнээс 209 нь Хятадын төв Телевиз, 31 нь мужийн TV станц, 3,000 нь орон нутгийн хотуудын станц)

Телевиз үзэгчид: 400 сая

Интернет хэрэглэгч: 45,8 сая (2002 оны байдлаар)

Тээвэр:

Төмөр зам: нийт: 71,600 км

Стандартын зам: 68,000 км 1.435 м-ийн замтай (14,600 км цахилгаан)

Нарийн зам: 3,600 км 1.000 м ба 0.750 м зам орон нутагт байгуулсан шугам

Хурдны зам: нийт: 1,402,698 км,

Дэвсгэртэй: 314,204 км (хамгийн бага хэмжээнд 16,314 км экспресс зам)

Дэвсгэргүй: 1,088,494 км

Усан зам: 110,000 км

Дамжуулах хоолой: хий 13,845 км; нефть 15,143 км; цэвэр бүтээгдэхүүн 3,280 км (2003 оны байдлаар)

Боомт болон далайн боомт: Далянь, Фужоу, Гуанжоу, Хайкоу, Хуанпу, Ляньюйган, Нанжин, Наньтун, Ниньбо, Циндао, Цинхуандао, Шанхай, Шаньтоу, Шэньжэн, Тяньжин, Вэньжоу, Сямэнь, Синган, Яньтай, Жанзянь.

Нисэх буудал: 500 (2002 оны байдлаар).

Цэргийн байгууллага: Хятадын Ардын Чөлөөлөх Арми (ХАЧА): цэргийн хүчнүүд бүгд багтана, Тэнгисийн цэргийн флот (усан цэрэг болон усан онгоц багтана), Агаарын хүчин, Артиллерийн II корпус ((стратегийн пуужингийн (ракетны) хүчин)), Ардын Армийн Цагдаагийн хүчин.

Цэргийн алба хаах нас: 18 нас. (2003 оны байдлаар)